

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/20/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2026 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер Б.Долгорсүрэн  
Утас: 261885 Цахим хаяг: [dolgorsurenb@audit.gov.mn](mailto:dolgorsurenb@audit.gov.mn)  
Ахлах аудитор П.Амарсанаа  
Утас: 261740 Цахим хаяг: [amarsanaap@audit.gov.mn](mailto:amarsanaap@audit.gov.mn)  
Аудитор Ж.Мөнхтуул  
Утас: 261740 Цахим хаяг: [munkhtuulj@audit.gov.mn](mailto:munkhtuulj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.3 Нэмэлт төсөв.....	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.1 Албан шаардлага.....	21
5.2 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГ	Шүүх шинжилгээний газар
ШШЕГ	Шүүх шинжилгээний ерөнхий газар
ШШХ	Шүүх шинжилгээний хэлтэс



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 787

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,701.5 сая төгрөгөөр давж, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд хөрөнгө, бараа материал худалдан авах, ажил гүйцэтгүүлэх гэрээг 27 хуулийн этгээдтэй байгуулж, жилийн эцэст нийт 1,805.9 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж, 2026 оны төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэх, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах эрсдэлийг бий болгосон;
- Хөтөл нутаг ХХК-тай байгуулсан тоног төхөөрөмж худалдан авах гэрээ болон худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт барааг хүлээж авсны дараа төлбөрийг төлөхөөр заасан боловч төлбөр төлөх нөхцөлийг зөрчин захиалагч тал төлбөрийг 100.0 хувь урьдчилж төлсөн нь гэрээний үүрэг хэрэгжихгүй байх эрсдэлтэй;
- Тайлант онд засварын ажил гүйцэтгүүлэх 115.0 сая төгрөгийн, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авах 29.0 сая төгрөгийн гэрээг байгуулсан боловч

засварын ажил хийгээгүй, зөвлөх үйлчилгээний тайлан ирүүлээгүй байхад харилцагч байгууллагатай гэрээний дүнгээр тооцоо нийлж, өглөгөөр тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах”, 41.2.4-т “төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Хууль, зүй дотоод хэргийн салбарын хөрөнгө оруулалтын зардалд 2025 онд 3,436.0 сая төгрөгийн Шүүх шинжилгээний салбарын тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөж, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Хөрөнгө оруулалтын үр дүнд Инженер-техникийн шинжилгээний газрын Барилга байгууламжийн шинжилгээний лабораторид барилгын бат бэх тодорхойлох багаж, тоног төхөөрөмжийг 222.0 сая төгрөгөөр, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвүүдэд тээврийн хэрэгслийн мэдээлэл уншигч EDR төхөөрөмжийг 619.5 сая төгрөгөөр, Кибер аюулгүй байдлын хэлтэст Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах сервер 231.2 сая төгрөгөөр, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл 273.0 сая төгрөгөөр тус тус худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Бүсийн шүүх шинжилгээний төв болон аймгийн Шүүх шинжилгээний хэлтэсүүдээс харъяа аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд санал, хүсэлт хүргүүлэн нийт 182.7 сая төгрөгийг шийдвэрлүүлж, алба хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулж, үзлэг, шинжилгээнд шаардлагатай багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Шүүх шинжилгээний ерөнхий газар төсвөөс санхүүжилт бууруулж, зарцуулах эрх олгогдоогүй байхад тайлант онд хуулийн этгээдтэй байгуулсан хөрөнгө худалдан авах болон бусдаар ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний нийт үнийн дүнгээр бараа материалыг их хэмжээгээр дараа тооцоогоор худалдан авсан, ажлын гүйцэтгэл гараагүй байхад гэрээний үнийн дүнгээр тооцоо нийлж баталгаажуулсан зэргээс шалтгаалж

жилийн эцсийн санхүүгийн тайланд их хэмжээний өглөг үүсгэж, дараа оны төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлсэн байна.

### **Бусад асуудал**

Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)-ийн хүрээнд 2025 оны 4 дүгээр сард Барилгын хөгжлийн төвөөр зураг төслийн магадлан дүгнэлт гаргуулж, орц, гарц, гүүрэн байгууламж барихад шаардлагатай 1,145.7 сая төгрөгийг Нийслэлийн 2026 оны төсөвт тусгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаалаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Удирдах хороог байгуулсан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,458,915.9	4,400,364.1
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	320,431.9	149,147.5
3	АВЛАГА	149,500.5	90,184.4
4	УРЬДЧИЛГАА	431,686.5	630,321.2
5	БАРАА МАТЕРИАЛ	2,120,956.8	2,651,441.7
6	НӨӨЦИЙН БАРАА	236,340.3	699,269.3
7	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	200,000.0	180,000.0
8	Бусад эргэлтийн хөрөнгө	200,000.0	180,000.0
9	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	35,806,582.4	35,784,062.7
10	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,806,582.4	35,784,062.7
11	Биет хөрөнгө	31,676,184.1	30,899,811.9
12	Биет бус хөрөнгө	4,130,398.3	4,884,250.8
13	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	39,265,498.4	40,184,426.8
14	НИЙТ ӨР ТӨЛБӨР	145,359.8	3,392,925.7
15	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	145,359.8	3,392,925.7
16	Өглөг	145,359.8	3,392,925.7
17	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	39,120,138.6	36,791,501.1
18	Засгийн газрын хувь оролцоо	39,120,138.6	36,791,501.1
19	Засгийн газрын оруулсан капитал	6,181,433.7	6,181,433.7
20	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,181,433.7	6,181,433.7
21	Хуримтлагдсан үр дүн	27,852,535.2	25,523,897.7
22	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,086,169.7	5,086,169.7
23	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	39,265,498.4	40,184,426.8

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	54,953,784.4	52,971,653.0
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,882,062.2	52,971,653.0
3	Тусламжийн орлого	319,744.0	52,141,205.9
4	Хандив тусламж /дотоод/	-	52,141,205.9
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	41,162,155.8	55,155,891.1
6	УРСГАЛ ЗАРДАЛ	41,162,155.8	55,155,891.1
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,341,142.8	50,601,737.3
8	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,820,410.2	32,650,790.9
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	669,025.8	948,795.8
10	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	735,277.0	783,478.3
11	Хангамж, бараа материалын зардал	1,266,431.5	1,309,241.5
12	Нормативт зардал	2,560,514.9	5,555,823.5
13	Эд хогшил, урсгал засварын зардал	1,124,375.5	741,592.2
14	Томилолт, зочны зардал	449,691.3	484,711.6
15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	588,041.2	1,095,008.8
16	Бараа үйлчилгээний бусад зардал	5,127,375.4	7,032,294.8
17	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,821,013.0	4,554,153.8
18	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	13,791,628.6	(2,184,238.1)
19	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,082,426.9	144,399.4
20	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(6,082,426.9)	(144,399.4)
21	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	7,709,201.7	(2,328,637.4)

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,410,936.9	-	31,410,936.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,941.4	-	1,941.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,412,878.3	-	31,412,878.3
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(1,941.4)	-	(1,941.4)
5	Тайлант үеийн үр дүн	7,709,201.7	-	7,709,201.7
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,120,138.6	-	39,120,138.6
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,120,138.6	-	39,120,138.6
8	Тайлант үеийн үр дүн	(2,328,637.4)	-	(2,328,637.4)
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,563,746.6	-	36,791,501.1

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	46,359,306.9	52,425,353.4
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	288,584.7	52,425,353.4
3	Нийтлэг татварын бус орлого	288,584.7	149,147.5
4	Тусламжийн орлого	-	52,276,205.9
5	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,712,650.0	47,161,345.3
6	УРСГАЛ ЗАРДАЛ	38,712,650.0	47,161,345.3
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,819,154.2	42,295,968.7
8	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,819,835.8	32,640,422.6
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	669,804.8	947,114.6
10	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	738,044.8	776,355.1
11	Хангамж, бараа материалын зардал	1,193,270.4	1,203,867.6
12	Нормативт зардал	3,632,665.5	3,700,598.6
13	Эд хогшил, урсгал засварын зардал	1,496,137.7	1,568,967.9
14	Томилолт, зочны зардал	468,269.2	466,593.7
15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,336,531.4	706,163.6
16	Бараа үйлчилгээний бусад зардал	464,594.6	285,885.1
17	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,893,495.8	4,865,376.6
18	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,646,656.9	5,264,008.2
19	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	7,458,182.5	5,435,292.6
20	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,458,182.5	5,435,292.6
21	Дотоод эх үүсвэрээр	7,458,182.5	5,435,292.6
22	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,458,182.5)	(5,435,292.6)
23	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	188,474.3	(171,284.4)
24	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	131,957.6	320,431.9
25	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	320,431.92	149,147.51

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	60,368,251,100.00	49,262,683,650.24	11,105,567,449.76	81.6
Татварын бус орлого	60,368,251,100.00	49,262,683,650.24	11,105,567,449.76	81.6
Тусламжийн орлого	60,368,251,100.00	49,262,683,650.24	11,105,567,449.76	81.6
Төсвөөс санхүүжих	60,368,251,100.00	49,262,683,650.24	11,105,567,449.76	81.6
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,368,251,100.00	49,262,683,650.24	11,105,567,449.76	81.6
УРСГАЛ ЗАРДАЛ	57,027,851,100.00	46,006,733,560.24	11,021,117,539.76	80.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,594,335,200.00	43,630,074,390.58	9,964,260,809.42	81.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,339,473,400.00	32,561,805,378.47	3,777,668,021.53	89.6
Үндсэн цалин	16,525,286,200.00	15,391,669,844.35	1,133,616,355.65	93.1
Нэмэгдэл	12,329,457,500.00	11,562,003,620.58	767,453,879.42	93.8
Унаа хоолны хөнгөлөлт	4,909,240,700.00	4,224,401,398.51	684,839,301.49	86.0
Урамшуулал	2,575,489,000.00	1,383,730,515.03	1,191,758,484.97	53.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,183,526,300.00	944,401,312.28	239,124,987.72	79.8
Тэтгэврийн даатгал	315,373,200.00	235,195,454.70	80,177,745.30	74.6
Тэтгэмжийн даатгал	62,867,700.00	28,691,423.76	34,176,276.24	45.6
ҮОМШӨ-ний даатгал	35,093,300.00	24,749,791.81	10,343,508.19	70.5
Ажилгүйдлийн даатгал	19,002,300.00	12,592,686.56	6,409,613.44	66.3
Эрүүл мэндийн даатгал	751,189,800.00	643,171,955.45	108,017,844.55	85.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	800,156,000.00	776,355,060.30	23,800,939.70	97.0
Гэрэл, цахилгаан	262,817,200.00	252,934,240.06	9,882,959.94	96.2
Түлш, халаалт	428,387,400.00	417,656,486.45	10,730,913.55	97.5
Цэвэр, бохир ус	72,286,600.00	68,360,133.79	3,926,466.21	94.6
Байрны түрээс	36,664,800.00	37,404,200.00	(739,400.00)	102.0
Хангамж, бараа материалын зардал	1,910,477,700.00	1,179,652,606.38	730,825,093.62	61.7
Бичиг хэрэг	456,434,900.00	182,646,858.00	273,788,042.00	40.0
Тээвэр, шатахуун	722,717,300.00	492,101,900.83	230,615,399.17	68.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	144,878,200.00	116,430,906.75	28,447,293.25	80.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,699,400.00	26,780,905.00	13,918,495.00	65.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	545,747,900.00	361,692,035.80	184,055,864.20	66.3
Нормативт зардал	5,925,837,500.00	3,700,598,554.40	2,225,238,945.60	62.4
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,002,395,500.00	2,377,870,507.08	1,624,524,992.92	59.4
Хоол, хүнс	242,383,900.00	176,789,275.00	65,594,625.00	72.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,681,058,100.00	1,145,938,772.32	535,119,327.68	68.2
Эд хогшил, урсгал засварын зардал	3,943,488,900.00	2,805,834,509.28	1,137,654,390.72	71.2
Багаж, техник, хэрэгсэл	1,718,445,300.00	1,467,256,381.00	251,188,919.00	85.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	738,511,100.00	193,704,910.00	544,806,190.00	26.2
Урсгал засвар	1,486,532,500.00	1,144,873,218.28	341,659,281.72	77.0
Томилолт, зочны зардал	608,921,300.00	390,733,488.00	218,187,812.00	64.2
Гадаад албан томилолт	93,016,600.00	77,281,910.00	15,734,690.00	83.1
Дотоод албан томилолт	458,404,700.00	308,174,494.00	150,230,206.00	67.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	57,500,000.00	5,277,084.00	52,222,916.00	9.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,766,001,400.00	1,236,686,692.47	1,529,314,707.53	44.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,949,336,100.00	628,633,639.32	1,320,702,460.68	32.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,244,900.00	2,646,000.00	6,598,900.00	28.6
Даатгалын үйлчилгээ	101,662,300.00	51,557,296.00	50,105,004.00	50.7
Тээврийн хэрэгслийн татвар	20,910,800.00	10,480,999.00	10,429,801.00	50.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	5,785,100.00	1,144,178.00	4,640,922.00	19.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	587,775,900.00	503,782,441.15	83,993,458.85	85.7
Газрын төлбөр	10,613,300.00	6,022,159.00	4,591,141.00	56.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	80,673,000.00	32,419,980.00	48,253,020.00	40.2
Бараа үйлчилгээний бусад зардал	116,452,700.00	34,006,789.00	82,445,911.00	29.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	116,452,700.00	34,006,789.00	82,445,911.00	29.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,433,515,900.00	2,376,659,169.66	1,056,856,730.34	69.2

**Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Бусад урсгал шилжүүлэг	3,433,515,900.00	2,376,659,169.66	1,056,856,730.34	69.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,903,849,100.00	2,302,025,719.66	601,823,380.34	79.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	254,798,100.00	-	254,798,100.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	274,868,700.00	74,633,450.00	200,235,250.00	27.2
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,340,400,000.00</b>	<b>3,255,950,090.00</b>	<b>84,449,910.00</b>	<b>97.5</b>
Тоног төхөөрөмж	3,340,400,000.00	3,255,950,090.00	84,449,910.00	97.5
БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	863	816	47	
Удирдах ажилтан	34	33	1	
Гүйцэтгэх ажилтан	804	759	45	
Үйлчлэх ажилтан	25	24	1	
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	863	816	47	
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	838	791	47	
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	3	3	-	
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22	22	-	
<b>НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ</b>	<b>33</b>	<b>33</b>	<b>-</b>	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

<b>Үзүүлэлт</b>	<b>Гүйцэтгэл</b>
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	692,673,346.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	692,673,346.00
Тусламжийн орлого	692,673,346.00
Хандив тусламж /дотоод/	692,673,346.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	692,673,346.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	164,433,312.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	501,531,970.00
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	26,708,064.00
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>663,277,485.98</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>663,277,485.98</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>663,277,485.98</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,617,172.00
Нэмэгдэл	2,492,030.00
Урамшуулал	76,125,142.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,713,270.98
Тэтгэврийн даатгал	870,150.00
Тэтгэмжийн даатгал	96,190.00
ҮОМШӨ-ний даатгал	48,090.00
Ажилгүйдлийн даатгал	48,090.00
Эрүүл мэндийн даатгал	1,650,750.98
Хангамж, бараа материалын зардал	3,889,260.00
Бичиг хэрэг	418,500.00
Тээвэр, шатахуун	2,780,560.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	690,200.00
Эд хогшил, урсгал засварын зардал	153,897,200.00
Багаж, техник, хэрэгсэл	116,017,200.00
Тавилга	4,280,000.00
Урсгал засвар	33,600,000.00
Томилолт, зочны зардал	75,860,175.00
Гадаад албан томиллолт	72,860,175.00
Дотоод албан томиллолт	3,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	348,300,408.00
Бараа үйлчилгээний бусад зардал	294,375,901.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,924,507.00
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>29,395,860.02</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(29,395,860.02)</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(29,395,860.02)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүх шинжилгээ бол шинжлэх ухаан, технологийн хөгжилд тулгуурлан нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын зэрэгцээ аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгт авсан ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй, хараат бусаар дүгнэлт гаргаж, хэрэг маргааныг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг салбар болно.

Шүүх шинжилгээний байгууллага нь 2025 онд “Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шинжлэх ухааны баталгаа болох” эрхэм зорилгын хүрээнд “Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцийг бүрдүүлэх”, “Олон улсын стандартыг төлөвшүүлж, магадлан итгэмжлэгдсэн лабораторид үзлэг, шинжилгээ хийх, хэргийн газрын үзлэг, шинжилгээний чанар, үр дүнг сайжруулах”, “Цахим шилжилтийг эрчимжүүлж, хиймэл оюун ухаан ашиглах” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шүүх шинжилгээний ерөнхий газар үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомжийг мөрддөг байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль.

Тайлант хугацаанд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/35 дугаар тушаалаар “Шинээр систем нэвтрүүлэх болон нэмэлт хөгжүүлэлт хийх журам”, Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын А/51 дугаар тушаалаар “Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө”, А/125 дугаар тушаалаар “Шүүх шинжилгээний байгууллагын сургалт, хөгжлийн журам”-ыг тус тус баталсан байна.
- Шүүх шинжилгээний ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2025 оны А/1 дүгээр тушаалаар “Галт зэвсгийн хонгио, хошууны адилтгал, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, ашиглах, хадгалах, хяналт тавих журам”, А/2 дугаар тушаалаар “Цогцос хүлээн авах, ангилах, хадгалах, хүлээлгэн өгөх, таньж тодруулах ажиллагааг зохицуулах журам”-ыг баталж, А/20, А/168 дугаар тушаалаар “Шүүх шинжилгээний байгууллагын Шагналын журам”, А/33 дугаар тушаалаар “Албаны дүрэмт хувцас болон хөдөлмөр хамгааллын хувцас олгох, хураан авах, тооцоо хийх журам”, А/74 дүгээр тушаалаар “Шүүх шинжилгээний байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Агентлагийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2024 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 918.9 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	320.4	149.1	(171.3)
Авлага	149.5	90.2	(59.3)
Урьдчилгаа	431.7	630.3	198.6
Бараа материал	2,121.0	2,651.4	530.4
Нөөцийн бараа	236.3	699.3	463.0
Бусад эргэлтийн хөрөнгө	200.0	180.0	(20.0)
Үндсэн хөрөнгө	35,806.6	35,784.1	(22.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>39,265.5</b>	<b>40,184.4</b>	<b>918.9</b>
Өр төлбөр	145.4	3,392.9	3,247.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	39,120.1	36,791.5	(2,328.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>39,265.5</b>	<b>40,184.4</b>	<b>918.9</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 149.1 сая төгрөг болж, өмнөх оноос 171.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>320.4</b>	<b>149.1</b>	<b>(171.3)</b>
Төрийн сангийн харилцах	320.4	149.1	(171.3)
<b>Дүн</b>	<b>320.4</b>	<b>149.1</b>	<b>(171.3)</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны 149.1 сая төгрөг нь ШШЕГ-ын 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар шинжилгээний багаж, тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлсэн 5 аж ахуй нэгжээс бараа, ажил үйлчилгээний чанарын баталгаа болгон байршуулсан барьцааны үлдэгдэл байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2025.07.28-ны өдрийн Б/420 дугаар "Урамшуулал олгох тухай" тушаалаар Шүүх шинжилгээний ерөнхий газрын хэмжээнд 5 албан хаагчид үндсэн цалинг 1.5 дахин, 12 албан хаагчид үндсэн цалинг 1 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү буюу нийт 37.6 сая төгрөгийн урамшуулал олгосон;
- Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/57 дугаар тушаалаар 5.7 сая төгрөгийг алба хаагчдын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зарцуулсан;
- Говьсүмбэр аймгийн шүүх шинжилгээний хэлтэс-Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4 хөрөнгийг одоогийн зах зээлийн үнэ ханштай харьцуулахад 2.2 сая төгрөгөөр илүү үнээр худалдан авсан;
- Нийслэлийн шүүх шинжилгээний газар-Тайлант онд спортын уралдаан тэмцээний хоол хүнсний зардалд 1.4 сая төгрөгийг зарцуулсан;
- Орхон аймгийн шүүх шинжилгээний хэлтэс- Багаж техник хэрэгслийн зардлаас 4.9 сая төгрөгөөр монгол гэр худалдаж авсан, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 0.2 сая төгрөгийг гэрээт албан хаагчаас суутгасан нийгмийн даатгалын зардалд гүйлгэн зарцуулсан.

**3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 90.2 сая төгрөг болж, өмнөх оноос 59.3 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	5.9	2.6	(3.3)
Татаас, санхүүжилтийн авлага	135.0	86.5	(48.5)
Байгууллагаас авах авлага	8.6	1.0	(7.6)
<b>Дүн</b>	<b>149.5</b>	<b>90.2</b>	<b>(59.3)</b>

*Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Ажиллагчтай холбоотой авлага дансны 2.6 сая төгрөгийн үлдэгдэлд Нийслэлийн ШШГ-ын 0.9 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн ШШХ-ийн 1.7 сая төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Татаас санхүүжилтийн авлагын 86.5 сая төгрөгийн үлдэгдэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын ахмадын сангийн үлдэгдэл 64.0 сая төгрөг, Дархан-Уул аймаг дахь бүсийн шүүх шинжилгээний төвийн ахмадын сангийн үлдэгдэл 1.6 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд Дархан-уул аймгийн Дархан сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 09-ны А/100 дугаар тушаалаар "Хууль сахиулах байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх зорилтын хүрээнд төрийн үйлчилгээ явуулах материаллаг бааз, иргэдийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг сайжруулах" зориулалттай өгсөн санхүүжилтийн үлдэгдэл 16.6 сая төгрөг мөн Дархан -Уул аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/609 дугаар "Хөрөнгө гаргах тухай" захирамжийн дагуу эзэнгүй цогцос оршуулах санхүүжилтийн 4.3 сая төгрөг байна.

Байгууллагаас авах авлага дансны 1.0 сая төгрөгийн үлдэгдэлд Ховд аймаг дахь бүсийн шүүх шинжилгээний төвд шинжилгээний объект хадгалах тусгай зориулалт бүхий чингэлэг худалдан авахаар аймгийн засаг даргын тамгын газраас 20.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээс үлдсэн 1 сая төгрөгийг авлага байна.

**3.4.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 630.3 сая төгрөг болж, өмнөх оноос 198.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	431.7	270.3	(161.4)
Урьдчилгаа тооцоо	-	360.0	360.0
<b>Дүн</b>	<b>431.7</b>	<b>630.3</b>	<b>198.6</b>

*Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилж гарсан зардал дансны 270.3 сая төгрөгийн үлдэгдэлд Шүүх шинжилгээний ерөнхий газрын тайлант онд тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж, тэтгэврийн урьдчилгаа авсан 4 албан хаагчийн 227.8 сая төгрөг, гэнэтийн ослын болон жолоочийн хариуцлагын даатгалын 4.9 сая төгрөг, Нийслэлийн шүүх шинжилгээний газрын иргэд, олон нийтэд соён гэгээрүүлэх чиглэлээр видео контент, тараах материал хийлгэх 37.6 сая төгрөгийн урьдчилгаа байна.

Урьдчилгаа тооцоо дансны үлдэгдэлд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө бэлтгэх 360.0 сая төгрөг бүртгэлтэй байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,651.4 сая төгрөг болж, өмнөх оноос 530.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>534.5</b>	<b>560.8</b>	<b>26.3</b>
Тусгай зориулалттай материал	274.1	212.5	(61.6)
Эм боох материал	260.4	348.2	87.9
<b>Хангамжийн материал</b>	<b>1,576.5</b>	<b>1,080.7</b>	<b>504.2</b>
Бичиг хэргийн материал	102.1	201.2	99.0
Аж ахуйн материал	188.2	174.9	(13.3)
Сэлбэг хэрэгсэл	0.5	1.5	1.0
Түлш, шатах тослох материал	53.3	41.9	(11.4)
Хүнсний материал	3.3		(3.3)
Бусад хангамжийн материал	1,229.0	1,661.2	432.2
Мал амьтад	10.0	10.0	-
<b>Дүн</b>	<b>2,121.0</b>	<b>2,651.4</b>	<b>530.5</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 7,919.8 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 91.2 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, зарцуулсан 7,412.6 сая төгрөгийн, акталсан 67.9 сая төгрөгийн бараа материал буурснаас шалтгаалан бараа материал дансны эцсийн үлдэгдэл 530.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 699.3 сая төгрөг болж, өмнөх оноос 462.9 сая төгрөгөөр өссөн байна

Хүснэгт 6. Нөөцийн бараа

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Нөөцийн бараа</b>	<b>236.3</b>	<b>699.3</b>	<b>462.9</b>
Бусад нөөц	236.3	699.3	462.9
<b>Дүн</b>	<b>236.3</b>	<b>699.3</b>	<b>462.9</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны үлдэгдэл 462.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1,654.6 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 82.2 сая төгрөгийн бараа тус тус нэмэгдэж, 1,273.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

### 3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 180.0 сая төгрөг болж, өмнөх оноос 20.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	200.0	180.0	(20.0)
<b>Дүн</b>	<b>200.0</b>	<b>180.0</b>	<b>(20.0)</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд Сэлэнгэ аймагт баригдаж байгаа барилгын ажлын хуримтлуулан бүртгэсэн 200.0 сая төгрөгөөс жилийн эцэст барьцаа дансанд байршиж байсан 20.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн дүнгээр буурсан байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 35,784.1 сая төгрөг болж, өмнөх оноос 22.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>31,676.6</b>	<b>30,899.8</b>	(776.4)
Барилга, байгууламж, орон сууц	12,689.6	13,011.2	321.5
Авто-тээврийн хэрэгсэл	3,971.9	3,739.5	(232.4)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,359.1	13,405.0	(954.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	642.4	714.7	72.4
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	-	26.0	26.0
Бусад үндсэн хөрөнгө	13.2	3.4	(9.8)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,130.4</b>	<b>4,880.3</b>	<b>1,935.7</b>
Программ хангамж	3,064.5	3,832.2	767.7
Бусад биет бус хөрөнгө	1,065.9	1,052.1	(13.8)
<b>Дүн</b>	<b>35,806.6</b>	<b>35,784.1</b>	<b>(22.5)</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 35,784.1 сая төгрөг болж өмнөх оноос 22.5 сая төгрөгөөр буурсан нь нөлөө бүхий өөрчлөлт гараагүй байна. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой ТӨБЗГ-ын дараах тогтоол, шийдвэрүүд гарсан байна: Үүнд:

- ТӨБЗГ-ын "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" 2025 оны 201 дүгээр тогтоолоор Нийслэлийн Шүүх шинжилгээний газраас Шүүх шинжилгээний ерөнхий газарт 10,321.5 сая төгрөгийн балансын үнэтэй 6,867.7 сая төгрөгийн үлдэх өртөгтэй машин тоног төхөөрөмж, 446.6 сая төгрөгийн балансын үнэтэй 369.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй тавилга эд хогшил, 1,464.2 сая төгрөгийн балансын үнэтэй 768.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй биет бус хөрөнгө, 153.0 сая төгрөгийн балансын үнэтэй 102.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй авто тээврийн хэрэгслийг балансаас балансад тус тус шилжүүлсэн.
- ТӨБЗГ-ын 2025 оны 368 дугаар "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай", мөн 737 дугаар "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолуудаар нийт 275.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 88.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, 39.9 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 2.6 сая төгрөгийн барилга байгууламж, 4.5 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон.
- ТӨБЗГ-ын 2025 оны 98 дугаар "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор 253.6 сая төгрөгийн балансын үнэтэй машин тоног төхөөрөмж, 10.0 сая төгрөгийн балансын үнэтэй тавилга эд хогшил, 15.3 сая төгрөгийн балансын үнэтэй биет бус хөрөнгийг, мөн 780 дугаар "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" тогтоолын дагуу 708.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 16.1 сая төгрөгийн тавилга эд хогшил, 3.5 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 4.8 сая төгрөгийн биет бус хөрөнгийг тус тус акталсан байна.

- ТӨБЗГ-ын 2025 оны А-1/1386 "Үндсэн хөрөнгө данснаас хасах тухай" албан бичгээр 41.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1.0 сая төгрөгийн тавилга эд хогшлыг тус тус акталсан.

### 3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,392.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3,247.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Өглөг</b>	<b>145.4</b>	<b>3,392.9</b>	<b>3,247.5</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	2.1	8.6	6.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2.2	2.2
Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг	142.3	149.1	6.8
Байгууллагад төлөх өглөг	1.0	3,229.9	3,228.9
Хувь хүмүүст төлөх өглөг	-	3.0	3.0
<b>Дүн</b>	<b>145.4</b>	<b>3,392.9</b>	<b>3,247.5</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажилчидтай холбоотой өглөгийн 8.6 сая төгрөгийн үлдэгдэлд ШШЕГ-ын 4.8 сая төгрөгийн, Говь-Алтай аймгийн ШШХ-ийн 3.8 сая төгрөгийн өглөг байна.

Бараа үйлчилгээний зардлын 2.2 сая төгрөгийн үлдэгдэлд Дундговь аймгийн ШШХ-ийн 1.0 сая төгрөгийн, Өмнөговь аймгийн ШШХ-ийн 1.2 сая төгрөгийн өглөг байна.

Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 149.1 сая төгрөгийн үлдэгдэлд ШШЕГ-ын хөрөнгө бэлтгэх барьцаа дансны үлдэгдэл байна.

Байгууллага болон хувь хүмүүст өгөх өглөгт Өмнөговь аймгийн ШШХ-ийн 0.5 сая төгрөгийн, Хөвсгөл аймгийн ШШХ-ийн 1.0 сая төгрөгийн, Ховд аймгийн ШШХ-ийн 1.0 сая төгрөгийн, ШШЕГ-ын 3,227.3 сая төгрөгийн өглөг тус тус бүртгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Тайлант онд худалдан авалт хийх, ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор 27 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, жилийн эцэст нийт 1,805.9 сая төгрөгийн төсвийн жилд төлөвлөгдөөгүй өр төлбөр үүсгэж, 2026 оны төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах эрсдэлийг бий болгосон.

### 3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 36,791.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2,328.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,181.4	6,181.4	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>27,852.5</b>	<b>25,523.9</b>	<b>(2,328.6)</b>
Өмнөх үеийн үр дүн	20,143.3	27,852.5	7,709.2
Тайлант үеийн үр дүн	7,709.2	(2,328.6)	(10,037.8)
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>5,086.2</b>	<b>5,086.2</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>39,120.1</b>	<b>36,791.5</b>	<b>(2,328.6)</b>

Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн бууралтаас шалтгаалан 2,328.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий агентлаг, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус агентлаг 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 173,399.2 сая төгрөгийн санхүүжилтээр, нийт зарлагыг 173,399.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хөрөнгө оруулалтын зардлыг 73,194.5 сая төгрөгөөр, цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 13,339.6 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 7,151.4 сая төгрөгөөр, нормативд зардлыг 6,895.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 3,983.8 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1,020.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 842.1 сая төгрөгөөр, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 748.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 744.9 сая төгрөгөөр, томилолт, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 635.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 36.8 сая төгрөгөөр тус тус бууруулж, гадаадад суралцагсдын зардлыг 26.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 64,833.0 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны баталсан төсвийг 4,464.8 сая төгрөгөөр бууруулж тодотгосон бөгөөд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 57,027.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 1 хөтөлбөр 1 арга хэмжээг 3,340.4 сая төгрөгөөр, нийт 60,368.2 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 49,262.7 сая төгрөгийн санхүүжилт авч, улсын төсөвт 2,320.8 сая төгрөг төвлөрүүлж, 8,700.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу санхүүжигдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 49,262.7 сая төгрөг буюу 81.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 11,021.1 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 84.5 сая төгрөгөөр дутуу санхүүжигдэж, зарцуулах боломжгүй байсантай холбоотой байна.

*Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
70707	<b>Шүүх шинжилгээ</b>	<b>60,368.2</b>	<b>49,262.7</b>	<b>11,105.5</b>	<b>81.6%</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	51,644.9	42,947.1	8,697.8	83.1%
80220	Холбооны суваг ашигласны хөлс	8.0	2.2	5.8	27.9%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	3,433.5	2,376.7	1,056.8	69.2%
80227	Лабораторийн итгэмжлэл	1,043.2	350.5	692.7	33.5%
80215	Эрдэм шинжилгээ, судалгаа	13.1	12.7	0.4	96.9%
81822	Гадаад суралцагсдын зардал	104.8	54.4	50.4	51.9%
82311	Шүүх шинжилгээний тусгай ажил үйлчилгээ	570.9	122.0	448.9	21.4%
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	209.4	141.1	68.3	67.3%
80918	Хөрөнгө оруулалт /барилга/	-	-	-	-
80918	Хөрөнгө оруулалт /тоног төхөөрөмж/	3,340.4	3,255.9	84.5	97.4%

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Шүүх шинжилгээний ерөнхий газар нь тайлант онд 863 орон тоотой ажиллагаас гүйцэтгэлээр 817 орон тоотойгоор ажилласан байна.
2. Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2024 оны 08-р сарын 30-ны өдрийн "Алба хаагчдын нийтийн тээврийн унааны болон хоолны зардлыг шинэчлэн тогтоох тухай" Б/408 дугаар тушаалаар албан хаагч нарт хоолны хөнгөлөлт 30.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 1.0 мянган төгрөг олгохоор тогтоосон.

3. Гадаад томилолтын зардалд 93.0 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 77.3 сая төгрөгийг гадаад сургалт, зөвлөгөөний зардалд зарцуулсан, мөн Авлигатай тэмцэх газраас “Хууль сахиулагч шинжээчдийг сургаж, дадлагажуулах, мэргэшүүлэх, дэвшилтэд техник, технологийг Монгол Улсад нэвтрүүлэх, шинжээчдийн хараат бус байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоотой танилцах, туршлага судлах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор” нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн 72.9 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
4. Тайлант онд албан хаагчдын чадавхжуулах сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 116.9 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 34.0 сая төгрөгийг зарцуулсан;
5. Шүүх шинжилгээний ерөнхий газар нь 30 нэр төрлийн 4,863.0 сая төгрөгийн санхүүгийн болон шинжилгээний программ хангамж бүртгэлтэй байгааг бүрэн ашиглаж байна. Тайлант онд программын хөгжүүлэхэд урсгал төсвөөс 4.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 1,294.8 сая төгрөг нийт 1,299.5 сая төгрөгийг зарцуулсан байна.
6. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, ямар нэгэн зардал гараагүй;
7. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 164.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 501.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 26.7 сая төгрөг, нийт 692.7 сая төгрөгийн орлогоор бүрдүүлж, урсгал зардалд 663.0 сая төгрөгийг зарцуулж, 29.4 төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-нд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 3,436.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, урсгал төсвөөс 12,942.0 сая төгрөгийн 10 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 7, харьцуулалтын аргаар 3 худалдан авахаар тусгаж, баталсан. Төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлээр 12,040.1 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

#### Аудитын илрүүлэлт

- Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын засварын ажил гүйцэтгүүлэхээр 115.0 сая төгрөгийн , ISO 45001: 2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авахаар 29.0 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч засварын ажил хийгдээгүй, зөвлөх үйлчилгээний тайлан ирүүлээгүй байхад харилцагч байгууллагуудтай гэрээний үнийн дүнгээр тооцоо нийлж, өглөгөөр тусгасан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн агентлаг, түүний гадаад, дотоод орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийг үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, аудитор Ж.Мөнхтуул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/2741 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 42,868.6 сая төгрөгийн 1 хувиар буюу 428.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор агентлаг болон дээд шатны төсөв захирагчаас төрийн хэмнэлттэй холбоотой тушаал, шийдвэр гарах, арга хэмжээ авах нөхцөл байдал үүсээгүй. 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой дараах зөрчил илэрлээ.

Илрүүлэлт 1. Тайлант онд ШШЕГ-ын даргын 2025 оны А/57 дугаар тушаалаар 5.7 сая төгрөгийг алба хаагчдын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, 3 дугаар зүйлийн 3.2-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шалгагдагч байгууллага нь тайлант онд шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 05/3015 дугаар албан бичгээр, хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 05/9487 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой 123.4 сая төгрөгийн 9 зөвлөмж, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 280.2 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн нотлох баримтад тулгуурлан үнэлэхэд 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	9	123.4	9	123.4	100.00
Албан шаардлага	3	280.2	3	280.2	100.00
<b>Нийт дүн</b>	<b>12</b>	<b>403.6</b>	<b>12</b>	<b>403.6</b>	<b>100.00</b>

/сая төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар 2025 оны жилийн эцэст ажил гүйцэтгүүлэх болон худалдан авах ажиллагаатай холбоотой үүссэн 1,805.9 сая төгрөгийн өглөгийг хэрхэн шийдвэрлэсэн талаар, мөн үндсэн хөрөнгө бэлтгэхээр хуулийн этгээдэд олгосон 360.0 сая төгрөгийн урьдчилгааны гүйцэтгэл буюу тоног төхөөрөмж хүлээн авсан эсэх асуудлуудыг үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангаа нэгтгүүлсэн харьяа 23 төсвийн байгууллагаас 10 байгууллагыг түүвэрт хамруулж, 13 байгууллагад дүгнэлт гаргасан.

Аудитад хамрагдсан 13 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 837.9 сая төгрөгийн 12 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 2,130.2 сая төгрөгийн 15 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 152.9 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 1,977.3 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,092.6 сая төгрөгийн 13 зөрчил илэрснээс, 152.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага, 1,939.7 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 2,130.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,701.5 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

#### 1. Ажил дүгнэж, тооцоо нийлэхтэй холбоотой

**Илрүүлэлт 1.** Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын засварын ажил гүйцэтгүүлэхээр 115.0 сая төгрөгийн , ISO 45001: 2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авахаар 29.0 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч засварын ажил хийгдээгүй, зөвлөх үйлчилгээний тайлан ирүүлээгүй байхад харилцагч байгууллагуудтай гэрээний үнийн дүнгээр тооцоо нийлж, өглөгөөр тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гэрээний үүргийн хэрэгжилт хангагдаагүй, нотлох баримтгүй байхад гүйцэтгэлийг үнэлж, тооцоо нийлж, өглөг үүсгэсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### 2. Дотоод хяналттай холбоотой

**Илрүүлэлт 2.** Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгжээс тавих хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2,092.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 152.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 1,939.7 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгсөн байна. Нийт зөрчлийн дүн өмнөх оноос 1,689.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 50-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

## **5.2 Зөвлөмж**

### **1. Өглөгтэй холбоотой**

**Илрүүлэлт 1.** Тайлант онд худалдан авалт хийх, ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор 27 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, жилийн эцэст нийт 1,805.9 сая төгрөгийн төсвийн жилд төлөвлөгдөөгүй өр төлбөр үүсгэж, 2026 оны төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах эрсдэлийг бий болгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 70 дугаар зүйлийн 70.5-д “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн жилд өр төлбөр үүсгэж, дараа оны төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлж, төсөвт ачаалал үүсгэхгүй ажиллах.

### **2. Бараа материалтай холбоотой**

**Илрүүлэлт 2.** Жилийн эцэст 3 компаниас нийт 121.8 сая төгрөгийн бичиг хэргийн материалыг дараа тооцоогоор нэг дор их хэмжээгээр худалдан авч, нөөц үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай хангамжийн материалыг нэг дор их хэмжээгээр авахгүйгээр хэрэгцээ шаардлагадаа нийцүүлэн худалдан авах.

### **3. Худалдан авах ажиллагаатай холбоотой**

**Илрүүлэлт 3.** Хөтөл нутаг ХХК-тай байгуулсан тоног төхөөрөмж худалдан авах гэрээ болон худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт барааг хүлээж авсны дараа төлбөрийг төлөхөөр заасан боловч төлбөр төлөх нөхцөлийг зөрчин захиалагч тал төлбөрийг 100.0 хувь урьдчилж төлсөн нь гэрээний үүрэг хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Тендерийн баримт бичгийн Гэрээний тусгай нөхцөл- 3.9-д “Нийлүүлэгч нь гэрээний үүргээ биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлт, төлбөрийн нэхэмжлэх зэрэг захиалагчид хүргүүлсэн баримтыг үндэслэн санхүүжилт олгох хүчинтэй хугацаанд багтаан төлбөрийг шилжүүлнэ”, Хөтөл нутаг ХХК-тай байгуулсан 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Гэрэл зураг боловсруулах машин нийлүүлэх” гэрээний 5.1-д “Нийлүүлэгч нь захиалагчийн заасан хугацаанд өөрийн

зардлаар барааг захиалагч талд хүргэж, хүлээлгэж өгөх үүрэгтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендерийн баримт бичиг, болон байгуулсан гэрээнд заасан нөхцөл, гэрээний зүйл заалтыг нягт мөрдөж ажиллах.

#### **4. Хөрөнгийн хяналт, хариуцлагатай холбоотой**

Илрүүлэлт 4. Тус байгууллагын агуулахад хадгалагдаж байгаа хөрөнгөд хяналт шалгалт хийхэд агуулах эмх цэгцгүй, хөрөнгө, бараа материалыг төрөлжүүлж ангилаагүй, эд хариуцагч болон бүртгэлээр тавих дотоод хяналт, хариуцлага сул байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 67 дугаар зүйлийн 1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, 68 дугаар зүйлийн 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хариуцагч агуулахад байгаа бараа материалыг төрөлжүүлэн цэгцлэх, албан хаагчдын жилийн хэрэгцээнд худалдан авсан нормын хувцаснуудыг албан хаагчдад яаралтай хуваарилж, хөрөнгийн орлого, зарлагыг цаг тухайд бүртгэж байх.

#### **5. Урамшуулалтай холбоотой**

Илрүүлэлт 5. Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын "Урамшуулал олгох тухай" 2025 оны Б/420 дугаар тушаалаар Шүүх шинжилгээний ерөнхий газрын хэмжээнд 5 албан хаагчид үндсэн цалинг 1.5 дахин, 12 албан хаагчид үндсэн цалинг 1 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү буюу нийт 37.6 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын төсвийг баталсан хуваарийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлан нэн шаардлагатай зардалд зарцуулж, албан хаагчдад шагнал, урамшууллыг давхардуулан олгохгүй, төсвийг үр ашигтай зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хэрэгжилтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Баян-Өлгий аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	719.9	1	719.9			1	719.9				
Говьсүмбэр аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	969.4			1	969.4	1	969.4				
Дорноговь аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	3	20,227.9			3	20,227.9	3	20,227.9				
Өмнөговь аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	3,834.9			1	3,834.9	1	3,834.9				
Төв аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	9,600.0			1	9,600.0	1	9,600.0				
Хөвсгөл аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	1,616.4			1	1,616.4	1	1,616.4				
Шүүх шинжилгээний ерөнхий газар	4	800,926.7	3	651,779.2	1	149,147.5	4	800,926.7				
<b>Нийт</b>	<b>12</b>	<b>837,895.2</b>	<b>4</b>	<b>652,499.1</b>	<b>8</b>	<b>185,396.1</b>	<b>12</b>	<b>837,895.2</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говьсүмбэр аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	2,228.8			1	2,228.8			-	-	-	-
Дорноговь аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	3	6,316.1			1	906.7	2	5,409.4	-	-	-	-
Нийслэлийн шүүх шинжилгээний газар	1	1,370.0					1	1,370.0	-	-	-	-
Орхон аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	5,140.0					1	5,140.0				
Шүүх шинжилгээний ерөнхий газар /аппарат/	6	2,077,559.7			2	149,802.3	4	1,927,757.4	-	-	-	-
Шүүх шинжилгээний ерөнхий газар	2	37,586.5			1		1	37,586.5	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>14</b>	<b>2,130,201.1</b>	-	-	<b>5</b>	<b>152,937.8</b>	<b>9</b>	<b>1,977,263.3</b>	-	-	-	-

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төв аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1070/АД170022

Улаанбаатар хот

САГ-2026/325/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2025 оны А/57 дугаар тушаалаар алба хаагчдын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулахад 5,720,000.00 (Таван сая долоон зуун хорин мянган) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-т “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа (Н.Ганбаяр), Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Н.Алтансүх), Ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч (Т.Батцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Ж.МӨНХТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1072/АД170022

Улаанбаатар хот

САГ - 2026/325/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын засварын ажил гүйцэтгүүлэх 115,082,342.00 (Нэг зуун арван таван сая наян хоёр мянга гурван зуун дөчин хоёр) төгрөгийн, ISO45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авах 29,000,000.00 (Хорин есөн сая) төгрөгийн гэрээг байгуулсан боловч засварын ажил хийгээгүй, зөвлөх үйлчилгээний тайлан ирүүлээгүй байхад харилцагч байгууллагатай гэрээний дүнгээр тооцоо нийлж, өглөгөөр тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийн хэрэгжилт хангагдаагүй, нотлох баримтгүй байхад гүйцэтгэлийг үнэлж, тооцоо нийлж, өглөг үүсгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа (Н.Ганбаяр), Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Н.Алтансүх), Ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч (Т.Батцэцэг), Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа (Д.Энхбаяр) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Ж.МӨНХТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1071/А0170022

Улаанбаатар хот

САГ-2026/20/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүх шинжилгээний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын нэгжийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2,092,614,615.00 (хоёр тэрбум ерэн хоёр сая зургаан зуун арван дөрвөн мянга зургаан зуун арван тав) төгрөгийн зөрчил илэрснээс 152,937,842.00 (Нэг зуун тавин хоёр сая есөн зуун гучин долоон мянга найман зуун дөчин хоёр) төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 1,939,676,773.00 (нэг тэрбум есөн зуун гучин есөн сая зургаан зуун далан зургаан мянга долоон зуун далан гурав) төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 50-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээ авч, зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа (Н.Ганбаяр), Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Н.Алтансүх), Ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч (Т.Батцэцэг) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
П.АМАРСАНАА  
Ж.МӨНХТУУЛ